



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/466

Мөрөн сум

Гэрээ байгуулах эрх олгож, захиалагчийн төлөөлөгч томилж, ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 60.1.2, 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйл, 22 дугаар зүйл, Засгийн газрын “Дүрэм шинэчлэн батлах тухай 2021 оны 212 дугаар тогтоол, “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 45 дугаар зүйлийн 45.3, 46 дугаар зүйлийн 46.1.3, 46.1.6, 46.3, Засгийн газрын “Захиалагчийн дүрэм батлах тухай” 2017 оны 170 дугаар тогтоол, Засгийн газрын “Журам батлах тухай” 2021 оны 160 дугаар тогтоол, Сангийн сайдын “Харьцуулалтын аргаар бараа худалдан авах тендерийн жишиг баримт бичиг батлах тухай” 2021 оны 124 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын “Байгууллагуудын хэрэгжүүлэх чиг үүрэг батлах тухай” 2022 оны А/95 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн авто замын сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжихээр батлагдсан Мөрөн сум доторх зам засвар арчилгаа ажил нийлүүлэх ХӨАОНӨГ/202312049 дугаартай тендерт 88,569,423 (Наян найман сая таван зуун жаран есөн мянга дөрвөн зуун хорин гурван) төгрөгийн үнийн санал ирүүлсэн “Хүслэнт Бүтээмж” ХХК-ийн тендерийг зөвшөөрч, тус компанид гэрээ байгуулах эрх олгохоор шийдвэрлэсүгэй.

2. “Хүслэнт Бүтээмж” ХХК-тай гэрээтэй холбоотой асуудлаар захиалагчийг төлөөлж харилцах, холбогдох шийдвэрийг гаргах, ажлын үе шатны хяналтыг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий “Захиалагчийн төлөөлөгч”-өөр “Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГазар (Д.Батчулуун)-ыг томилж, авто замын засвар арчилгаа хийх ажлыг ашиглалтад хүлээн авах хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Б.Должинсорогдог (Аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга)

Ажлын хэсгийн гишүүд: Н.Шинэбаяр (Аймгийн газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын хот байгуулалтын кадастр, зураг төсөл, магадлалын асуудал хариуцсан мэргэжилтэн)

Э.Наранчимэг (Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төвийн авто замын хяналтын инженер)

С.Мөнх-Эрдэнэ (Мөрөн хот тохижилт үйлчилгээний төвийн гүйцэтгэх захирлын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга: Н.Буян-Өлзий (Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн авто замын хяналтын улсын байцаагч)

3. ДААЛГАХ НЬ:

3.1. Мөрөн сум доторх зам засвар арчилгаа ажил нийлүүлэх гэрээнд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх, ажлын гүйцэтгэлд үе шатны хяналт хийх, ил далд

d/A4

6710011011

ажлын актыг баталгаажуулах, гэрээ болон гэрээний хэрэгжилтийн мэдээллийг төрийн худалдан авах ажиллагааны цахим систем, хөрөнгө оруулалтын үр ашгийг үнэлэх цогц системд тус тус нийтлэх, барилга байгууламжийг ашиглалтад оруулахад шаардлагатай баримт бичгийг бэлтгэж аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хүргүүлэх, барилгын ажлын үе шатанд хяналт хийж, захиалагчийн төлөөлөгчийн чиг үүрэг хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тайлагнах, уг тайланг хавтаст хэрэг болгон Орон нутгийн өмчийн газрын архивт хүлээлгэн өгөх үйл ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулахыг “Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв ОНӨААТҮГГазар (Д.Батчулуун)-д.

3.2. Мөрөн сум доторх зам засвар арчилгааны ажлыг ашиглалтад оруулах ажиллагааг хууль журмын дагуу зохион байгуулж, холбогдох баримт бичгийг Орон нутгийн өмчийн газрын архивт хүлээлгэн өгөхийг Орон нутгийн өмчийн газар дарга (Б.Должинсорогдог)-д.

3.3. Захиалагч, тендерт оролцогч (тухайн тендерт оролцсон нийт оролцогч)-ийн тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг зохион байгуулсан баримт бичиг, гэрээт ажлын үе шатны хяналтыг хийж, баталгаажуулсан техник хяналтын нэгдсэн дүгнэлт, зохиогчийн дүгнэлт, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авсан шийдвэр, санхүүжилтийн гүйцэтгэл зэрэг баримт бичгийг цахим болон бичгийн хэлбэрээр хавтаст хэрэг болгон Орон нутгийн архивт шилжүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Минжүүржаргал)-д.

4. Барилгын ажлын үе шатны хяналтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг гэрээний дагуу “Хөвсгөл барилга захиалагчийн хяналтын төв” ОНӨААТҮГ-т, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах ажиллагаатай холбогдон гарах зардлыг ажил хүлээн авах ажлын хэсгийн гишүүдэд тус тус олгохыг Орон нутгийн өмчийн газар (Б.Должинсорогдог)-т зөвшөөрсүгэй.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтэс (Б.Оюунтуяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ